



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Боловсролын салбарын ёс зүйн жил зарлах,  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.17 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оныг "Боловсролын салбарын ёс зүйн жил" болгон зарласугай.
2. "Боловсролын салбарын ёс зүйн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.
3. Батлагдсан төлөвлөгөөнд үндэслэн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг бүх шатны сургалтын байгууллагын удирдлагуудад, шаардагдах зардлыг санхүүжүүлж, хэрэгжилтийг ханган, хагас, бүтэн жилээр нэгтгэн тайлагнан ажиллахыг Боловсролын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар М.Энх-Амгалан/-т даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

142210374

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
 2022 оны 01 дүгээр сарын 03 ны өдрийн  
 .../01... дүгээр тушаалын хавсралт

### БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЁС ЗҮЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцан хэрэгжүүлэх, хамтран ажиллах байгууллага
<b>Нэг. Эрх зүйн орчныг сайжруулах, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах</b>					
1.1	Бүх шатны боловсролын байгууллагын ёс зүйн зөвлөлийг албан хаагчдын саналд үндэслэн байгуулах, бүрэлдэхүүнийг шинэчлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах, тайлангаа улирал тутамд хэлэлцүүлж хэвших.	I, II улиралд	Сургалтын байгууллага бүрд "Ёс зүйн зөвлөл" байгуулагдсан байна.	Ёс зүйн зөрчил, өргөдөл гомдол өмнөх оноос буурсан байна.	Бүх шатны боловсролын сургалтын байгууллага
1.2	Байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт зэрэг дотоод эрх зүйн баримт бичигт ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн хариуцлагын чиглэлээр холбогдох зорилт, заалтыг тусган шинэчлэн батлах, мөрдүүлэх арга хэмжээ авах.	II, III, IV улиралд	Байгууллагын дотоод эрх зүйн баримт бичгүүд шинэчлэгдсэн байна.	Ёс зүйн зөрчил, өргөдөл гомдол өмнөх оноос буурсан байна.	Бүх шатны боловсролын сургалтын байгууллага
1.3	Төрийн албан хаагчийн болон боловсролын байгууллагын багш, удирдах ажилтан, бусад ажилтны ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод эрх зүйн баримт бичгийг нийт багш, ажилчдыг судлуулах, сурталчлах арга хэмжээ авах. /Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/243 дугаар тушаал /	I, II улиралд	Ёс зүйн хэм хэмжээг мөрддөг байна.	Ёс зүйн зөрчил, өргөдөл гомдол өмнөх оноос буурсан байна.	Бүх шатны боловсролын сургалтын байгууллага
1.4	Суралцагчийг үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагааны чиглэл боловсруулж, батлуулах.	II улиралд	Чиглэл батлагдсан байна.	Суралцагчийг үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлж, таслан зогсоох ажлууд хийгдсэн байна.	БШУЯ



1.5	Ерөнхий боловсролын сургуулийн багшийн нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөл, ёс зүйн чадамжийг дэмжих, суралцагчийн нийгэм-сэтгэл хөдлөлөө удирдах хувь хүний үр чадварыг хөгжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх "SEEL" хөтөлбөр, арга хэмжээний удирдамж батлуулах, хэрэгжилтийг хангах.	Жилийн турш	Зорилтот сургуулиудад SEEL хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна.	Сургалтад хамрагдсан багш, суралцагчийн тоо	БШУЯ, БЕГ, НБГ, БШУГ
1.6	Электрон тамхины хэрэглээг хязгаарлах, хориглох асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх.	II, III улиралд	Хүүхэд, залууст электрон тамхины худалдахгүй, хэрэглээг хориглосон байна.	УИХ, Засгийн газрын шийдвэр гарсан байна.	БШУЯ
1.7	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны боловсролын баримт бичигт хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, дүрэм, журмыг шинэчлэх.	I, II улиралд	Боловсролын баримт бичгийн зөрчлийг бууруулсан байна.	Боловсролын зөрчилтэй баримт бичгийн тоо, эзлэх хувь	БШУЯ
1.8	Боловсролын сургалтын байгууллага дахь ургийн модыг илрүүлэх арга хэмжээ зохион байгуулж, багш, удирдах болон бусад ажилтныг сэлүүлэн ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.	Жилийн турш	Шийдвэр гарсан байна.	Зохион байгуулсан арга хэмжээ, түүний үр дүн	БШУЯ, БЕГ, НБГ, БШУГ
<b>Хоёр: Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах</b>					
2.1	Бүх шатны сургалтын байгууллагын орчин дахь суралцагч-суралцагч, багш-суралцагч, багш-багш, эцэг эх асран хамгаалагч-багш, багш-ажилтан хоорондын ялгаварлан гадуурхалт, дээрлэлтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр сургалт, хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулах.	Сар тутам	Арга хэмжээнд суралцагч, багш, эцэг эх, ажилтнуудыг хамруулсан байна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хамрагдсан суралцагч, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчдын тоо/эзлэх хувь	Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, Аймгийн БШУГ, НБГ, БХ, Монголын бага, дунд хувийн сургуулиудын холбоо, хувийн цэцэрлэгүүдийн холбоо, ИДСКонсерциум, Суралцагчийн өөрийн удирдлагын байгууллага, Бусад ТББ
2.2	Багшийн мэргэжлийн ёс зүй, сургалтын байгууллагын соёлыг сайжруулах, нийгмийн соён гэгээрүүлэхэд боловсролын ажилтны үүрэг, оролцоо зэрэг сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах.	Улирал тутамд	Мэргэжлийн ёс зүй, байгууллагын соёлын чиглэлээр хийгдсэн судалгааны дүнг олон нийтэд танилцуулж, эмхэтгэлийг цахим хэлбэрээр түгээсэн байна.	Илтгэлийг цахим хэлбэрээр түгээсэн суваг, хандалтын тоо	БШУЯ, БЕГ, БСҮХ, МУБИС
2.3	Хүмүүжлийн зэрэг арга хандлагыг төлөвшүүлэх үндэсний сургалтыг үе шаттай зохион байгуулах, харилцан туршлага солилцох арга хэмжээг зохион байгуулах.	I-III улиралд	Цэцэрлэг, сургуулийн нийт багш, ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна.	Сургалтад хамрагдсан багш, ажилтны тоо, хувь	НБГ, БШУГ



2.4	"Сургалтын байгууллагын орчин дахь үе тэнгийн дээрлэлтээс урьдчилан сэргийлэх, зогсоох арга зам, шийдэл" үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулах.	Улиралд	Төр, төрийн бус байгууллагын оролцоотой үндэсний хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	Санал, зөвлөмж гарсан байна.	УИХ-ын БСШУС-ын Байнгын хороо, БШУЯ, БЕГ
2.5	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын өөрөө удирдах байгууллагыг чадавхжуулах, үе тэнгийн дээрлэлт, гадуурхлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ажлыг тодорхой сэдвүүдээр кейсэд суурилсан хэлэлцүүлэг, ярилцлага, уулзалт, зорилтот ажлыг суралцагчдын манлайлал дор зохион байгуулах.	Жилийн турш	Сурагчдын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаа тогтворжсон байна.	СӨУБ-аас зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүүхдийн тоо	БЕГ, НБГ, БШУГ
2.6	Их, дээд сургууль, коллеж, МСУТ-ийн оюутнуудад мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, дүрэм журмыг судлуулах, оюутны зөвлөл, оюутны хөгжлийн төвүүдээр дамжуулан ёс зүйн чиглэлээр хэлэлцүүлэг, аян, өдөрлөг зохион байгуулах.	Улирал тутамд	Оюутнуудын суралцаж буй мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, дүрэм журмыг судалж, мэдсэн байна.	Оюутнуудын дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, аян, өдөрлөг, түүнд оролцогчдын хувь	Их, дээд сургууль, коллеж, МСУТ, ИДСКонсерциум, ТББ
<b>Гурав: Ёс зүйн жилийн хүрээнд зохион байгуулах нөлөөллийн үйл ажиллагаа</b>					
3.1	Бүх шатны сургалтын байгууллагын суралцагчдын харилцаа, хандлага, харилцаж буй үг хэллэгт ажиглалт хийх, харилцааны соёл төлөвшүүлэх зорилтот арга хэмжээг үе шаттай зохион байгуулах.	Улирал тутамд	Мэндлэх, хүндлэх уучлал гүйх, доромж үг, хараал хэлэхгүй байх зан үйлд дадуулж, үгсийн баялгийг нэмэгдүүлсэн байна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, аймгийн БШУГ, НБГ, БХ
3.2	Багш, ажилтанд стрессээс сэргийлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлын төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах.	Улирал тутамд	Багш, ажилтны харилцаа хандлага эерэг өөрчлөлтүүд гарсан байна.	Ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдлын тоо /өмнөх онуудтай харьцуулсан/	Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, аймгийн БШУГ, НБГ, БХ
3.3	Багш, ажилтан, оюутан суралцагч, эцэг эхийн ёс зүйн эерэг хандлага, эерэг үйлдэл, үйл ажиллагааг түгээх, сурталчилах, нийгмийн сүлжээнд давалгаа /challenge/ өрнүүлэх.	Жилийн турш	Эерэг хандлагыг нийтэд түгээсэн байна.	Сурталчилсан кейсийн тоо	Эцэг эхийн зөвлөл, сурагчдын зөвлөл, Оюутны зөвлөл, багш нарын зөвлөл
3.4	Эцэг, эх асран хамгаалагчдын зөвлөгөөн зохион байгуулах.	3 дугаар сард	Хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан санал, дүгнэлтийн мөрөөр зөвлөмж, чиглэл хүргүүлсэн байна.	Хэлэлцүүлэгт оролцсон хүний тоо, гарсан саналын тоо, авсан арга хэмжээний үр дүн	БШУЯ, БЕГ, БШУГ, НБГ, БХ
3.5	"Сайдад и-мэйл илгээгээрэй" 14 хоногийн аян зохион байгуулах, захидлын мөрөөр арга хэмжээ авах.	2 дугаар сард	Ирүүлсэн захидалд шинжилгээ хийж, зөрчлийг арилгах чиглэл зөвлөмж гаргасан байна.	Захидлын мөрөөр авсан арга хэмжээ	БШУЯ



3.6	Тусгай хэрэгцээт суралцагчийн эрхийг хамгаалах, ялгаварлалтаас сэргийлэх зорилгоор "Хандлагаа өөрчилъё" үндэсний болон орон нутгийн түвшний хэлэлцүүлэг зохион байгуулах.	4 дүгээр сард	Хэлэлцүүлгийг зохион байгуулж, гарсан санал, дүгнэлтийн мөрөөр зөвлөмж, чиглэл хүргүүлсэн байна.	Хэлэлцүүлэгт оролцсон хүний тоо, гарсан саналын тоо, авсан арга хэмжээний үр дүн	БШУЯ, БЕГ, БШУГ, НБГ, БХ
3.7	Суралцах орчны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн аян зохион байгуулах. "Аюулгүй сургууль", "Дотуур байр-Дулаан орчин"	Жилийн турш	Суралцах орчны аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлсэн байна.	Зохион байгуулсан аян, түүний дүн	Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, аймгийн БШУГ, НБГ
3.8	Хүүхэд багачууд, оюутан залуусын нас сэтгэхүйн хөгжилд нийцсэн ёс суртахуун, ёс зүй, монгол хүний үнэт зүйлийг тусгасан сургалт өгүүлэг, ном, бүтээл, контент, комик, анимэйшн зэрэг үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах.	Жилийн турш	Хүүхэд багачууд, оюутан залууст ёс зүй, монгол хүний үнэт зүйлийг түгээсэн байна.	Бүтээл, контент, арга хэмжээний тоо, давтамж	БШУЯ, БЕГ, ТББ
3.9	Сэтгэлзүйчийн цахим зөвлөгөөг тогтмол зохион байгуулах. /утас, пэйж, чат, захидал, бусад/	Жилийн турш	Мэдээллийн нээлттэй сувгуудыг ажиллуулж, сэтгэлзүйн зөвлөгөө өгсөн байна.	Ажиллуулсан нээлттэй суваг, түүнд хандсан мэдээллийн тоо	Бүх шатны боловсролын сургалтын байгууллага, аймгийн БШУГ, НБГ, БХ, Монголын бага, дунд хувийн сургуулиудын холбоо, ИДСКонсерциум, ТББ
3.10	Нийгмийн сүлжээ дэх хүний эрхийн зөрчил, цахим хүчирхийлэл, дээрлэхэлт, үе тэнгийн гадуурхлаас урьдчилан сэргийлэх, цахим халдлагаас хамгаалах, сурагч, оюутан, эцэг эх, багшийн цахим боловсролыг нэмэгдүүлэх, цахим орчин дахь аюулгүй, зохистой үйл ажиллагаа, мэдээллийг түгээх чиглэлээр хамтарсан зорилтот ажлуудыг зохион байгуулах.	жилийн турш	Багш, сурагчдад цахим хүчирхийлэл, доромжлол, гадуурхал, дээрлэхэлт зэрэг сөрөг нөлөөллөөс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар мэдлэгтэй болсон байна. Холбогдох "Санамж бичиг" байгуулсан байна.	Санамж бичгийн хүрээнд зорилтот арга хэмжээний нэр, төрөл, тоо, хамрагдсан багш, сурагч, оюутны тоо	БШУЯ, БЕГ, ИДС, "Гэрэлт цамхаг сан Монгол" ТББ
3.11	"Боловсролын салбарын ёс зүйн жил"-ийн хүрээнд олон нийтэд зориулсан соён гэгээрүүлэх контент, бүтээл, мэдээ мэдээллийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлж ажиллах.	Улирал тутамд	Эерэг хандлагыг нийтэд түгээсэн байна.	Түгээн дэлгэрүүлсэн контент, бүтээлийн тоо	БШУЯ, БЕГ, БШУГ, НБГ, БХ
3.12	Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, цахим контент боловсруулах, хэрэгжилтийг хангах.	жилийн турш	Цахим гарын авлага, контент боловсруулж, түгээсэн байна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, сургуулийн тоо	БЕГ, НБГ, БШУГ